



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 4/09

Баян-Овоо

┌ Баримт бичиг нягтлан шалгах комиссын ┐
ажиллах дүрэм журам, бүрэлдэхүүнийг
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын “Баримт бичиг нягтлан шалгах комиссын ажиллах дүрэм”-ийг нэгдүгээр, “Баримт бичиг нягтлан шалгах комиссын ажиллах журам”-ыг хоёрдугаар, Баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ын ажиллах дүрэм, журмыг гишүүдэд танилцуулж, цаашид архивын үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Б. Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш. ГАНГАНТУУЛ